

## Эрүүл мэндийн байгууллагын үүсэл

Анагаах ухаан, заслын үүслийн эхэн үе МЭӨ-209 он

Эмнэлгийн тусламжийн туршлага хуримтлагдаж, анагаах эмч бий болсон үе МЭӨ-209-1206

Анагаах ухааны тогтолцоо үүсэхийн өмнөх үе 1206-1578 он

Анагаах ухааны сургууль байгуулагдсан Монголын анагаах ухааны сургалт, онол практикийн үндэс болсон үе 1578-1921 он

Социализмын үеийн Монголын уламжлалт анагаах ухаан 1921-1990 он

Монгол уламжлалт анагаах ухааны шинэ тогтолцооны үе /1990 оноос хойш/ гэсэн үе шатлалаар хуваасан нт нэлээд шинэлэг, тодорхой, цаашид судалгаандаа харгалзан үзүүштэй үечлэл гэж тооцмоор болжээ.

Европын 1921 оны 08 дугаар сарын 15-ний өдөр Нийслэл Хүрээний газар Олноо Өргөгдсөний 11-р он 7сарын 12-ний өдөр Монгол Ардын бүх цэргийн зөвлөлийн газар, Бүх цэргийн жанжин Сүхбаатар түшмэд нар хуралдан тогтоосон тавдугаар бичиг”

“Өвчтэй хүмүүсийн эмчлэх хороо байгуулах тухай” хороо нь:

- 1.Өвчтэй хүмүүсийг эмчлэх газрыг дэлгэрүүлж 210 хүний суух байр болгов.
2. Энэхүү эмчлэх хороонд Совет /Зөвлөлт/-ийн Оросын ангийн цэргүүд Монгол ардын цэргүүд ба энгийн хүмүүст нэгэн адил тусламж үзүүлэнэ.
3. Аливаа өвчтэй хүн бүхнийг үнэгүй эмчлэх
4. Энэхүү зөвлөн тогтоосон зүйлийг тэргүүн сайчуудын хуралд өргөн батлуулна.

"Бүх цэргийн жанжин Сүхбаатар түшмэд нар гэжээ. Энэхүү тогтоолын дагуу улсын анхны эмнэлэг Нийслэл хүрээнд байгуулагдсан өдрийг Эрүүл мэндийн ажилтны өдөр болгон тэмдэглэдэг билээ.Тус нь эмнэлгийн хороо нь Төвд Европ эмнэлгийг хосолсон бөгөөд анагаах ухааны мэргэжилтэн илрүүлэх тусламж хүссэн тухай үед гарч байсан.

1921-1923 онд авч хэрэгжүүлсэн төр нийгмийн арга хэмжээний дотор МАХН-ын 2 дугаар их хурлаас анхдугаар их хурлаас батлагдсан түмэнд тунхаглан зарлах бичгийн 9 дүгээр зүйлийг өөрчлөн "Бас олон ард, элдэв зүйлийн халдвартай өвчин шарх тэргүүтнээс үлэмж гэмтэж бүхий учир хүн эмнэлгийн явдлыг хүндэтгэн үзэж, тарилга, цэвэрлэгээ үнэ төлөөсгүй эмнэлгийн орон байр байгуулах зэргийг эрхэм болгосугай" хэмээн ардын хувьсгал ялсны дараа бодит нөхцөл байдалд тулгуурлан хүн амын эрүүл мэндийн талаар баримтлах бодлого чиглэлээ тодорхойлсон.

1923 онд ЗХУ-ын эмч нарын шууд оролцоотойгоор цэргийн эмнэлгийг 1924 оны 4 дүгээр сард консулын суурины улаан байшингийн дээд давхрын 4 өрөөнд 36 ортой үлгэр жишээ эмнэлэг болгон өргөтгөж улмаар 1924 онд хуралдсан улсын анхдугаар их хурлын шийдвэрийн дагуу 1925.07.01-энд Дотоод яамны дэргэдэх эрүүлийг хамгаалах департамент /газар/ байгуулж, мөн оны 10 сард улсын төсвийн хөрөнгөөр ажиллах иргэний европ эмнэлгийн байгуулсан нь одоогийн улсын клиникийн 1 дүгээр эмнэлгийн суурь болжээ.

Нийслэл хүрээний бузар бүртгийг цэвэрлэн арилгаж хог шороог нь тусгаар хол газраа агуулж, үргэлж цэвэр эсэн мэнд сууцгаавал мөн улсын санд тус болно хэмээн МАХН-ын 3 дугаар хурлын тогтоолд заажээ.

Монгол улсын, Нийслэл хотод эрүүл мэндийн салбарыг үүсгэн хөгжүүлэхэд хэлмэгдүүлэлт, дайн, зүүнтний хэлбэрдэл зэрэг нийгэм, улс төрийн ээдрээтэй байдал маш муугаар нөлөөлж байлаа.

1925-1930 оны эмнэлгийн цэг бага багаар нэмэгдэж эмнэлгийн суурь баттай тавигдсан.

1926-1929 онуудад Монголд ажилласан РСФСР-ийн /ариун цэврийн болон эмнэлэг судалгаа, эрүүлжүүлэх, экспедиц/ эмнэлэг ариун цэврийн 3 удаагийн экспедиц

нийслэлийн ард иргэдэд эмнэлгийн үндсэн мэргэжлийн тусламжийг анхан үзүүлж, үзлэг эмчилгээг гардан гүйцэтгэж өвчлөлийн анхны тоймыг гаргасан.

Эмнэлэг ариун цэврийн 3 экспедиц 1929.09 дүгээр сараас 1930 оны 9 дүгээр сар хүртэл Улаанбаатар хот болон аймгийн хүн амд эмнэлгийн тусламж үзүүлэх, халдварт өвчний голомт судлах чиглэлээр ажилласан.

1930-1940 онуудад эмнэлгийн дунд мэргэжилтэн дотооддоо бэлтгэж эхэлсэн.

Эмнэлгийн боловсон хүчин бэлтгэх арга хэмжээ нь эрүүлийг хамгааллын хөгжлийн үе шатлалтай нягт, уялдан явагдсан байна. Өөрөөр хэлбэл

1921-1930 оны хооронд эмнэлгийн боловсон хүчин бэлтгэх бэлтгэл ханах үе 1930-1940 оны үед ихэвчлэн ЗХУ-д дээд дотооддоо дунд мэргэжилтэн бэлтгэсэн үе

1940-1960 онд дотооддоо дээд мэргэжилтэн бэлтгэсэн үе

1960- оноос хойш үндэсний эмнэлгийн дээд, дунд мэргэжил-тэнг бэлтгэн нарийн мэргэжлийг эрчимтэй эзэмшүүлсэн үе гэж үзүүштэй байна.

Эмнэлэг ариун цэврийн 4 буюу эмнэлэг шинжилгээний 1 экспедицийг 1933 оны 5 дугаар сараас 1935 оны 2 сар хүртэл ажилласан.

Эмнэлгийн 5 дугаар экспедиц буюу эрдэм шинжилгээний 2 экспедиц их эмч А.А.Азархын удирдлагаар 1936-1938 оны 8 дугаар сар хүртэл 16 хүний бүрэлдэхүүнтэй /8 их эмч, 8 дунд мэргэжилтэн/-ээр Улаанбаатар хот зарим аймгуудад ажиллаж хүн амын өвчлөл, нас бар алтыг голчлон судалж, Эрүүлийг хамгаалахын ерөнхий болон зарим эмнэлгийн бүтэц зохион байгуулалтыг судлан зөвлөмж боловсруулсан.

Ингэж 1926-1938 онуудад РСФСР-ийн эмнэлэг ариун цэврийн 5 удаагийн экспедиц ажилласан нь шинжлэх ухааны эмнэлэг, түүний үр нөлөө дэлгэрэх, шашин, лам нарын нөлөө нэр хүнд буурахад нөлөөлж, Монгол улс Нийслэл Улаанбаатар хотын хүн амын эрүүл мэндэд үнэтэй хувь нэмэр оруулсан.

Монголын ард түмний амьдрал ахуй, улс орны хөгжилд ихээхэн хохирол учруулсан 1939, 1945 оны Японы эзлэн түрэмгийлэх дайн эрүүлийг хамгаалахын хөгжилд ихээхэн саад болсон билээ. Монгол улс үндэсний эрүүлийг хамгаалах салбар шинэ тутам хөл дээрээ зогсох төдий байсан дайны жилүүдэд цэргийн төв болон Улаанбаатар хотын эмнэлэг мэргэжилтэн дайны талбарт нүүлгэн шилжүүлэх, ялган хуваарилах госпитал байгуулах, фронт ар тал нийт хүн амын дунд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд анхаарч байжээ.

Дотоод яамны дэргэдэх Эрүүлийг хамгаалах газар, улмаар ЭХЯ-ны зөвлөх байсан И.Л.Баевский "1930 оны Монгол ард улсын эрүүлийг хамгаалахын 1930-1935 оны 5 жилийн төлөвлөгөө" авч хэрэгжүүлэх арга хэмжээнийхээ төслийг бичсэн. 1930 оны эхээр Улаанбаатар хотод 80 гаруй мянган хүн ам байв.

1931 оны 01 сарын 01-энд төв эмнэлгийн дэргэд 80 ор бүхий 2 Платтыг 1 их эмч үзлэгийн кабинет тайгаар "Идэвхтний тасаг" байгуулагдсан нь хожим сайд нарын эмнэлэг, одоогийн клиникийн 2 дугаар эмнэлгийн эх үүсвэр болжээ.

Монгол улсын болон нийслэлийн эмнэлгийн байгууллага, тусламж үйлчилгээ 1930-аад оны дараахан харьцангуй нэмэгдэж, 1931 оноос төв эмнэлгийн дэргэд хүүхдийн болон чих хамар хоолойн, 1932 оноос хүлээн авах, физик эмчилгээний, 1933 оноос эмэгтэйчүүдийн, 1935 онд сүрьеэ гийн тасгийг байгуулсан.

1933 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Сайд нарын Зөвлөлийн 9 дүгээр хурлаар Ариун цэврийн хянан харгалзах асуудлыг хэлэлцэж дүрмийн санааг гаргаж, Улаанбаатар хотын Ариун цэврийг хянан харгалзах байдлын тухай дүрмийг баталжээ.

1980-1990 онуудад Монгол улсын эрүүл мэндийн бүхэл бүтэн үндэсний армитай болж нэг их эмчид 200 гаруйхан хотын иргэн ногдох хэмжээнд очсон.

1960 онд Улаанбаатар хотод их эмч 530, эмнэлгийн дундаж мэргэжилтэн 569 хүн эрүүл мэндийн үйлчилгээнд ажиллаж байсан. Орны тоо 3415 хүрч 1959 онд Эмийн

заводыг байгуулсан нь эмийг дотооддоо үйлдвэрлэх, эмийн түүхий эдийг ашиглах явдалд чухал нөхцөл болсон байна.

Эмнэлгийн байгууллага анх татсан нэртэйгээр байгуулагдаж байсан эмнэлгийн цэг салбар бие даасан эмнэлгийн байгууллага болон өрх тусгаарласны дотор 1947 онд халдвартын эмнэлэг, 1950 онд сүрьеэ гийн больниц, 1951 онд 1 амаржих газар, 1959 онд 2 дугаар амаржих газар, 1952 онд хүүхдийн больниц, 1954 онд мэс заслын больниц, одоогийн Клиникийн 3 дугаар эмнэлэг, 1960 онд баруун хороодын эмнэлэг хожимдоо хүүхдийн халдварт гепатитын эмнэлэг дараа нь хүүхдийн сүрьеэ гийн эмнэлэг болсон 1961 онд Цацраг туяа эмнэлэг буюу одоогийн Халдвартын судлалын төв тус тус байгуулагджээ.

1950 онд Төв хороо, Сайд нарын Зөвлөлийн тогтоолын дагуу төв эмнэлгийн мэдрэлийн тасгийг сэтгэл мэдрэлийн больництой нэгтгэн Туул голын хөвөөнд ажиллуулж, орыг 185 болгон лаборатори, рентген, физик эмчилгээний салбартай болж, 1943 оноос нугасны ус авах, 1955 оноос инсулины эмчилгээ, 1956 оноос шүүхийн сэтгэц магадалгаа, 1957 оноос аминазин эмчилгээг тус тус нэвтрүүлсэн байна.

1949 онд СНЗ-ийн тогтоолоор төв эмнэлгийн дэргэдэх эх барих эмэгтэйчүүдийн тасгийг бие даасан больниц болгон зориулалтын зураг төслөөр барилга барьж 1951 онд ашиглалтад авч "Төв төрөх" нэртэйгээр ажиглуулжээ.

1950 онуудад Улаанбаатар хотод тусгай мэргэжлийн диспансерууд томоохон эмнэлгүүд байгуулагдсан.

"Ард олны эмнэлгийн үйлчилгээг сайжруулах тухай" МАХН-ын Төв хороо, СНЗ-ийн 1950 оны 06 дугаар сарын 17-ний өдрийн 153/34 дүгээр тогтоолоор эрүүлийг хамгаалахын удирдлагын ажилд оршиж байсан дутагдлыг зааж эрүүлийг хамгаалахын хэлтсийн дарга нарыг их эмчээр тавьж эхэлсэн. 1955 оны 03 дугаар сарын 29-нд МАХН-ын Төв хороо СНЗ-ийн "Эрүүлийг хамгаалах ажлыг сайжруулах арга хэмжээний тухай" 124/98 дугаар тогтоол гарч эмнэлгүүдэд эмчилгээ- хамгааллын дэглэм нэвтрүүлэх хотын эмнэлгүүдэд хөдөөгийн эмнэлгийн шифрлүүлэх, эмнэлгийн байгууллагын зураг төсөл хийх, жил бүр эмнэлгийн тэргүүний ажилтны зөвлөгөөн хийж, тодорхой нэг асуудлыг хэлэлцэж байхаар тогтсон.

1952 онд Намын Төв хороо СНЗ-ийн "Тус улсын хүн амын дотор арьс өнгөний өвчинтэй тэмцэх тэмцлийг өрнүүлэх арга хэмжээний тухай тогтоол гарч, 1952-1956 онд Монгол Зөвлөлтийн эрүүлжүүлэх отряд ажилласан.

1958-1960 онд арьс өнгө сүрьеэгийн, 1959-1961 сүрьеэгийн эрүүлжүүлэх отряд ажилласан. 1956 оны 01 сарын 20-онд УБ хот СНЗ-н 16 дугаар тогтоолоор "Цус сэлбэх эмчлэх газрыг байгуулсан.

Намын төв хороо СНЗ-н 1948 оны 93/19 дүгээр арьс өнгөний өвчинтэй тэмцэх арга хэмжээний тухай заасны дагуу Улаанбаатар хотын намын хороо, захиргааны 1948.05.27-ний өдрийн 40/37 дугаар хурлаар Хотын хүн амд арьс өнгөний үзлэг явуулах тухай Хотын комисс байгуулсан.

СНЗ-н 1948 оны 06 сарын 11-ний өдрийн 173 дугаар тогтоолоор хүнс тэжээл бэлтгэх, зөөх худалдаалахад ариун цэврийг сахих, урьдчилан сэргийлэх тарилга хийх, халдварт өвтэй хүнийг тухай бүр хэвтүүлэн эмчлэх УБ хотод ариун цэвэр, бактериологийн лаборатори байгуулах шинжилгээг ундны ус хүнсний зүйлд хийж байхаар заасныг биелүүлж ажилд Нийслэлийн захиргаа, эрүүлийг хамгаалах хэлтэс идэвхтэй оролцжээ.

УБХ-н хөдөлмөрчдийн депутатуудын бага хурлын тэргүүлэгчдийн 1948 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 46 дугаар тогтоолоор Хотын захиргааны аж ахуйн хэлтсийн харьяанд байсан 50 ор бүхий тэтгэврийн газрыг хотыг ЭХХ-ийн харьяанд шилжүүлсэн.

1949 онд Хотын Эрүүл хамгаалах хэлтсийн харьяанд арьсны өвчтэй хүүхдийг эмчлэх 50 ортой салбарыг "Туул рестораны баруун талд захын конторын ойролцоо байгуулж "Захын доктор" нэртэй ажиллаж байсан.

1953 оны байдлаар Нийслэлийн Эрүүлийг хамгаалах хэлтсийн харьяанд албан газрын дэргэдэх ор бүхий салбар 8, түүний ор 55, ясли 8 түүний ор 425, сургуулийн дэргэдэх бага эмчийн салбар 12 байв.

СНЗ-ийн 1957 оны 433 дугаар тогтоолоор УБХ-ын хүн амын тооллогыг 1957 оны 12 сарын 14-15 -анд явуулсан. 1958 оны бүртгэлээс хойш 10 гаруйхан сарын дотор хотын хүн ам 28,4% буюу 33561 хүнээр нэмэгдэж, 151948 болсон нь шинэ үйлдвэр, аж ахуйн газар нэмэгдэж барилга байшин, баригдаж хүн ам эрүүл мэнд сайжирч байгаатай холбон үзсэн.

СНЗ-н 1958 оны 284 дүгээр тогтоолоор УБХ-ноо хороо бүрд хүүхдийн эмнэлэг үйлчилгээний хэсгийн систем бий болгож хэсэг бүрд их эмч, сувилагч москвич машинаар ажиллуулах болов. энэ нь эх хүүхдийн эргэлт, үзлэг тусламжийн хэсэг гэрээр идэвхтэй явуулах амбулаторийн анхны нэгж болж дэвсгэр нутгаар нь үйлчлэх дэвшилттэй зохион байгуулалт болсон бөгөөд одоогийн өрхийн эмчийн тогтолцооны эх үүсвэр бий болсон.

1953-1957 оны буюу 2 дугаар таван жилийн төлөвлөгөөг баталжээ. Өрхийн эмнэлгийн анхны суурь хэлбэр нь 1960 оноос доктор Мо.Шагдарсаүрэнгийн санаачлагчаар амбулатори-поликлиникийн анхан шатны нэгж болон Хүүхдийн хэсэг нэртэйгээр байгуулагдсан. Зохион байгуулалтын энэ хэлбэрийг анх нийслэлийн Найрамдлын районд туршилтын журмаар ажиллуулсан.

1961 он Улаанбаатар, Налайх хотын эмч нарын ажил төрлийн зөвлөгөөнийг "Хэсгийн систем, диспансерчлал" сэдвээр зохион байгуулах.

1961 оноос хотын бүх хороодод их эмчийн оройн цагийн үзлэг зохион байгуулах

1963 оноос нэгдсэн хэсгийн зохион байгуулалтад орж бие даасан нэгж болж төсөв төлөвлөгөөнд, тусгасан.

1962-1963 онуудад Эрүүлийг хамгаалах яам, Улаанбаатар хотын намын хороо АДХ-ын Гүйцэтгэх захиргаа Эрүүлийг хамгаалах газраас нэгдсэн системийн аж ахуйн зохион байгуулалтын хувьд бэхжүүлэхийн тулд орон байр, аж ахуйн хангамж, тоног төхөөрөмж, эмнэлгийн багаж хэрэгсэл мэргэжлийн боловсон хүчнээр хангах нэлээд арга хэмжээ авч явуулсан.

Нэгдсэн хэсгийн систем нь харьяалсан хүүхдийн бүртгэл явуулж, өөрийн үйлчлэх дэвсгэрийн товчилсон зураг гаргаж, хороодын захиргаатай хамтран эрүүлжүүлэх нэгдсэн төлөвлөгөөг зохион ажиллаж харьяалсан хөдөлмөрчдийнхөө өмнө тайлангаа тавьдаг болсон.

1969 оны ЭХЯ-ны тусгай заавар анкетаар нийт эмч нарын бүртгэлийн гүйцэтгэв.

1970 онуудад төлөвлөгөөгөөр зарим алслагдсан хороодын нэгдсэн хэсгийн системд рентген кабинет клиник лаборатори байгуулж тоног төхөөрөмж мэргэжлийн боловсон хүчнээр хангав.

1980 онд Улаанбаатар эмнэлгүүдийн байгууллагууд нь Эрүүлийг хамгаалах яам, хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа төмөр замын хэрэг эрхлэх газар болон бусад яам газарт хамрагдаж хотын хөдөлмөрчдөд эмнэлгийн тусламж үзүүлж байв.

1986 оны Улаанбаатар хотын хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламжийн талаар авах зарим арга хэмжээний тухай

ЭХЯ, Хотын захиргааны 1986 оны 53/70 дугаар тушаал тогтоолын дагуу Улаанбаатар хотод ажиллаж байгаа хэсгийн цехийн эмнэлгүүдийг дэвсгэр нутгийн байршлаар нь нэгтгэх, өндөр настан Тээвэрчдийн эмнэлгийн дотрын эмч гэмтэл, хавдар, халдварт, сэтгэл мэдрэл зэрэг нарийн мэргэжлийн кабинетуудыг тус тусын районы амбулатори-поликлиникт төвлөрүүлэн хүн мад ойртуулах, районы нэгдсэн эмнэлэгт

клиник-биохимийн лаборатори, байгуулж, боловсон хүчин урвалж, тоног аппаратаар хангах 1986-1987 онд багтаан Улаанбаатар хотод дотрын 60 хэсэг байгуулсан.

1986-1990 онуудад нийт хүн амыг диспансерчлах туршилт судалгааг явуулахаар Анагаах ухааны хүрээлэнгээс гаргасан удирдамж аргачлалыг ЭХЯ баталж, судалгаа явуулах түшиц газрыг ажиллагсдын хувьд Улаанбаатар хотын поликlinik, Сүхбаатар, Ажилчны районы нэгдсэн поликlinik нэгдсэн хэсгийн 2 хэсэг хүүхдийн амбулатори поликlinik эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх газар, хүүхэд эх барих, эмэгтэйчүүдийн хэсэг байхаар тогтоосон.

1993 оноос өрхийн эмнэлгийн шинэ тогтолцоонд орсон дэвшил гаргаагүй ба 2000-2003 оноос өрхийн эмнэлгийн тогтолцоо шинэчлэл улам боловсронгуй болсон.

1991 онд Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагын түүхэнд онцлон тэмдэглэх үйл явдлаар нэлээд дүүрэн байсан

Хотын эрүүл мэндийн нэгж байгууллагуудын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үйлчилгээний шат дамжлага давхардлыг арилгах, хөдөлмөрчдийн чирэгдлийг багасгах, эмнэлгийн үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах талаар нэлээд арга хэмжээ эхэлсэн. 1991 онд Улаанбаатар хотод эрүүл мэндийн зөвлөх төв /ЭМЗТ/ 6, Эрүүл мэндийн төв /ЭМТ/ 12 ажиллаж байсан. 1992 онд Улаанбаатар хотын түргэн тусламжийн авто баазыг түргэн тусламжийн станцтай нэгтгэн "Түргэн тусламжийн төв байгуулсан.

ЭМЯ, Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргаа ны 1991.03.26 өдрийн А/39/83 дугаар тушаал захирамж, "Нийслэл дэх эрүүл мэндийн зарим байгууллагын зохион байгуулалтыг шинэчлэн өөрчлөх тухай" шийдвэр гаргасан.

- Монгол улсын орон нутгийн хурлын болон улсын төсвийн тухай хуулийг үндэслэн Эрүүл мэндийн яамны харьяа нийслэл дэх улсын үйлчилгээ бүхий эмнэлэг урьдчилан сэргийлэх байгууллагуудыг Улаанбаатар хотын харьяалалд шилжүүлж, хот улсын үйлчилгээтэй ажиллуулах,

- Нэгдсэн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, эмнэлгүүдийн биеэ даасан байр бүхий поликlinikуудыг "Нарийн мэргэжлийн төв" болгох

- Дүүргүүдэд "Эрүүл мэндийн зөвлөх төв" "Дэвсгэр нутгийн эрүүл мэндийн төв" зохион байгуулж, дүүргийн сүрьеэ, арьс өнгөний диспансер, халдварт, сэтгэл мэдрэлийн зэрэг кабинетыг Эрүүл мэндийн зөвлөх төв шилжүүлсэн

- Дүүргийн АЦХСС-ыг Хотын Эрүүл ахуй халдвар судлалын хяналтын газрын салбар болгон ажиллуулах,

- Дүүргүүдийн АХГЗ-ны Эрүүлийг хамгаалах, нийгэм хангамжийн хэлтсийг татан буулгаж, орон тоо цалингийн санг дүүргийн эрүүл мэндийн эрүүл мэндийн зөвлөх төвд шилжүүлсэн.

- Хотын хүн амын эрүүл мэндийн байдалд дүгнэлт хийж бодлого боловсруулах үндсэн үүрэг бүхий орон тооны бус нэгдсэн зөвлөлийг дүүргийн Эрүүл мэндийн зөвлөх төвийг түшиглүүлэн байгуулсан.

- Хотын 3,4,19,20,23,24,32,40,41,42,44,45 дугаар яслиудыг архаг өвчтэй хүүхдийг эрүүлжүүлэх сувиллын ясли болгох, бусад яслиудыг байршлын байдлаар нь нэгтгэх зарим бололцоотой яслид цэцэрлэгийн анги нээх

- Нийслэлд шинээр байгуулагдаж буй Эрүүл мэндийн зөвлөх ба дэвсгэр нутгийн төвийн дүрмийг баталж эрүүл мэндийн байгууллагууд шинэ нэршлийг тогтоож үйлчлэх хүрээ хуваарийг шинэчилсэн.

Монгол улсын Засгийн газрын 1992 оны 25 дугаар тогтоолын дагуу Улаанбаатар хотын ЭХГ-ын нэршил, бүтэц зохион байгуулалтыг өөрчилсөн.

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эрүүл мэндийн сайдын 1993 оны А/114 тоот тушаалыг биелүүлэх зорилгоор Нийслэлийн эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллага хүмүүст эмнэлэг үйлчилгээний ажил эрхлэх зөвшөөрөл

олгох мэргэжлийн хяналт тавих комиссыг эрүүл мэндийн газрын даргаар ахлуулсан 16 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулав.

1993 оны А/4 дүгээр тушаал "Өрхийн эмчийн тогтолцоонд шилжих тухай" гарч хүн амд үзүүлэх бэлтгэл ажлыг хангах шийдвэр гарч өрхийн эмчийнсажллах зааврыг шинэчлэн баталжээ.

Эрүүл мэндийн сайдын 1993 оны А/141 дугаар тушаал "Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын талаар авах хэвшлийн байгууллагын ололт дутагдлыг тэмдэглэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг баталсан.

НИТХ-ын 1996 оны 16 дугаар тогтоол гарч "Нийслэлийн Эрүүл мэндийн хөтөлбөрийг батлуулж, ажилласан нь Нийслэлийн Эрүүл мэндийг хамгаалах нийгэм, эдийн засаг, анагаах ухаан биологийн арга хэмжээг өргөтгөн иргэдийн үүрэг хариуцлагыг дээшлүүлж, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг зах зээлийн харилцаанд шилжүүлэхэд зохих үр дүн өгсөн.

Нийслэлд эрүүл мэндийн төв байгуулж, өрхийн эмчийн тогтолцоонд шилжиж олон шинжит эрүүл мэндийн тогтолцообий болж, даатгал нэвтэрч, үргүй зардал багассан зэргийг дүгнэн Нийслэлийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах ажлыг 1996-2000 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг баталсан.

Хүн амын эрүүл мэндийн байдалд жил бүр дүгнэлт өгч, тулгамдсан зорилтуудыг НИТХ-ын Тэргүүлэгчдийн болон Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, шийдвэр гаргаж мөрдөх эмнэлгийн байгууллагад үзүүлэх дэмжлэг туслалцааг өргөтгөх, эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах, эрүүл мэндийн үзлэгт жил бүр оруулах эрүүл мэндийн боловсрол олгох ажлын зохион байгуулах зэргийг хот дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосон байна.

Нийслэлийн эрүүл мэндийн 2000-2004 оны үндсэн стратеги, үндсэн болон үйл ажиллагааны зорилтыг анх удаа боловсруулсан. Нийслэлийн эрүүл мэндийн салбарын 2001-2004 оны стратегийн зорилт үйл ажиллагааны үндсэн зорилтыг НИТХ-ын 2001 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 07 тоот тогтоолоор баталсан.

Монгол улсын Засгийн газрын 2000 оны 186 дугаар тогтоол, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 225 тоот тушаал, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2001 оны 07 дугаар тогтоолыг үндэслэн Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын шинэ нэршлийг оновчтой болгож, эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Засаг даргын 2001 оны 98/197 тоот хамтарсан тушаал захирамжаар баталсан байна.

Энэ шийдвэрээр нийслэлийн эрүүл ахуйн халдвар судлалын албыг " НЭМ-ийн хяналтын алба" дүүргийн Эрүүл мэндийн төвүүд /2,3,4,5,6,8,10,13,15,16/ -ийн үйл ажиллагааг нутаг дэвсгэрийн салбар амбулаторийн хэлбэрээр зохион байгуулж дүүргийн Эрүүл мэндийн нэгдлүүдэд нь харьяалуулсан. Түүнчлэн хүүхдийн нэгдсэн 3,4 эмнэлгийг "дүүргийн нэгдсэн эмнэлэг" сувиллын яслиудыг дэвсгэр нутгийн "клиник сувилал" болгон тус тус зохион байгуулсан.

2004,2005 онуудад Нийслэлийн Эрүүл мэндийн газар тодорхой зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлсэн нь нийслэлийн хүн амын эрүүл мэндэд нааштай өөрчлөлтүүдийг бий болгожээ. 2005 он Хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил мөн Цахим эрүүл мэндийн дэд хөтөлбөрийг боловсруулсан 2006 онд Сувилахуйн үйл ажиллагааг дэмжих жил, 2007 онд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх жил, НЭМГ-с дэвшүүлсэн зорилт бол хүний нөөцийн чадвхийг дээшлүүлэх,эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг сайжруулах чвдал байлаа.